



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 4/3

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.4.5 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалтыг хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Цэрэнлхам

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн

Гишүүд: Д.Улам-Ундрах

Хурлын зохион байгуулалт хариуцсан Мэргэжилтэн

Д.Одмаа

Төрийн өмчийн удирдлага,
Зохицуулалтын хэлтсийн
Мэргэжилтэн

Д.Сувдмаа

Төрийн өмчийн хяналт шалгалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ө.Саранцэцэг

Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Л.Нарантуяа

Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хамруулан, 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2022 оны III улиралд багтаан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Н.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ